

ДӨЧ ГОЛЫН ГЕОМОРФОЛОГИЙН ОНЦЛОГ

Я.Болд, Г.Чинбат

Геологи Минералогийн тэнхим

Ордын талбайн өнөөгийн геоморфологийн дүр төрх бүрэлдэхэд ялгавартай явагдсан тектоник хөдөлгөөн, түүнийг дагасан экзоген процессууд болон морфоструктурын блокуудыг бүрдүүлж буй суурь чулуулгийн тогтоц, физик механикийн шинж чанарууд гол үүрэг гүйцэтгэсэн байна.

Талбайн гадаргуугийн гарал үүсэл, морфологийг харгалзан:

1. Идэгдэл-зөөгдлийн гаралтай гадаргуу
2. Зөөгдөл-хуримтлалын гаралтай гадаргуу гэсэн хоёр төрөлд хувааж үзлээ.

Идэгдэл-зөөгдлийн гаралтай гадаргуу нь тухайн нутгийн хэмжээнд явагдсан неотектоник хөдөлгөөн түүний ялгаварт чанар, гадаад хүчний үйл явц, тэдгээрийн эрчим, морфоструктурын блокийг бүрдүүлж байгаа чулуулгийн литологи, петрографийн шинж чанараас хамаарч харилцан адилгүй хөгжсөн байна. Энэхүү гадаргуугийн төрөл нь тухайн нутгийн ихэнх хэсгийг хамарсан гадаргуугийн үүсэл хөгжлийг тодорхойлж байгаа гадаргуугийн гол төрөл болно.

Идэгдэл зөөгдлийн гаралтай гадаргуу нь:

а/ Усан хагалбарын

б/ Уулын хажуугийн гадаргуу гэсэн хоёр төрөлд ангилагдана.

Усан хагалбарын гадаргуу нь уул нуруудын оройн хэсгээр янз бүрийн өндрийн түвшинд байрлана. Энэ гадаргуугийн

хэмжээнд гадаргуу нь эрчимтэй идэгдэлд өртөж зөөгдлийн эх үүсгэвэр болдог байна.

Уулын хажуугийн гадаргуу нь идэгдэл, элэгдлийн үр дүнд үүссэн, зөөгдлийн дундаж муж маягаар бий болсон налууугийн хэмжээ, сэвсгэр хурдасны зузаанаараа ялгаатай гадаргуу юм.

Зөөгдөл-хуримтлалын гаралтай гадаргуугийн төрөл нь уулын илэгдэл зөөгдлийн гадаргуугийн онцлог бүрдүүлж буй чулуулгийн литологи, петрографийн шинж чанарт нь тулгуурлан доорх үндсэн морфоструктурын гурван блокыг ялгалаа. Үүнд:

1. Битүүгийн цухуйц
2. Битүүгийн налуу энгэр
3. Дөч голын сав газрын хотгор

Эдгээр үндсэн морфоструктурын, структур-тектоникийн бие даасан блокууд, блокын хувьд янз бүрийн цаг үед явагдсан неотектоник хөдөлгөөн, үүнээс уламжлаад гадаргуугийн хэлбэр үүсэл, хөгжил харилцан адилгүй байна. Иймэрхүү жигд хөгжлөөс шалтгаалан усан хагалбарын гадаргуугийн хэлбэр, өндрийн түвшингээрээ ялгагдах хэд хэдэн ярусыг ялгаж болох юм.

Хамгийн их үнэмлэхүй өндөртэй /1100-1130 м/ усан хагалбарын гадаргуунуудад доод триасын тунамал чулуулгаас тогтсон идэвхтэй өргөгдсөн усан хагалбарын энэ гадаргуунуудад 80-120 м харьцангуй өндөржилттэй эрчимтэй хэрчигдсэн эгц хажуутай /налууугийн өнцөг 45 хүртэл/ рельеф ордын орчимд ажиглагдана. Гадаргуугийн хэлбэр нарийн хадан гарш ба нилээд гүн ховил үүсгэсэн өндөржилт харьцангуй ихтэй сэвсгэр хурдас багатай, заримдаа үндсэн чулуулаг Ү хэлбэрийн огтлол үүсгэсэн байдаг.

Резюме

Особенности геоморфологии Дөч гол

В данной работе освещены особенности структурно-геоморфологического строения района по результатам полевых исследований авторов. Выделены три морфоструктур (блок):

1. Битүүтинский выступ
2. Битүүтинский промежуточный блок
3. Прогиб бассейна "Дөч" гол

АШИГЛАСАН БҮТЭЭЛҮҮД

1. "Геоморфология МНР" издательство "Наука", Москва. 1982
2. Я.Болд "Геоморфологийн үндэс ба судалгаа" Улаанбаатар. 1987